

## **МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ**

Огноо: 2022 оны 6 дугаар сарын 9-ний өдөр  
Хурал хуралдсан газар: Монголын МСС-ийн “Туул” хурлын танхим

### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ**

Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 9 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг батлав.

Хоёрдугаар асуудал. Монголын МСС-ийн 2022.07.01-нээс 2023.06.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлав.

Гуравдугаар асуудал. Монголын МСС-ийн 2022 оны 3 дугаар улирлын Санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг батлав.

Дөрөвдүгээр асуудал. 2023 оны Улсын төсөвт тусгах Засгийн газрын хариуцах санхүүжилтийн саналтай танилцав.

Тавдугаар асуудал. Монголын МСС-ийн Санхүүгийн хариуцлагын төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлав.

Зургаадугаар асуудал. Монголын МСС-ийн Дотоод аудитын багийн Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийг төслийг батлав.

Долдугаар асуудал. Хөрөнгийн болон автомашины паркийн менежментэд хйисэн дотоод аудитын дүнтэй танилцав.

Наймдугаар асуудал. 2021.04.01-нээс 2022.03.31-ний хооронд хийгдэх хараат бус аудитын төлөвлөгөөтэй танилцав.

Есдүгээр асуудал. Бусад асуудал.